



# ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛ ЭХЭЛЖ БАЙНА

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН  
ДУНД СУРГУУЛИЙН ЗАЙН  
СУРГАЛТЫН  
ГАРЫН АВЛАГА



Arlington  
Public  
Schools

## ЗАХИРЛЫН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

### **АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ЭЦЭГ ЭХЧҮҮД ЭЭ,**

Дэлхий даяар тархсан цар тахлын улмаас Арлингтоны Улсын Сургууль нь 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн сургалтаа бүтэн цагийн зайн сургалт болгож, 9 сарын 8-ны өдрийн Мягмар гаригт эхлэх гэж байна. Бид бүх сурагчдаа сургуульдаа эргэн суралцахыг баяртай хүлээж байгаа бөгөөд хосолсон шатны сургалтын үед аюулгүй байдлыг хангах үүднээс КОВИД-19 өвчний үйл явцыг байнга хянаж байх болно.

Бид сургуулийн сургалтын алба, хуваарьт сургуулиудын веб сайт, цахим шуудан болон бусад тогтсон харилцаа холбоогоор дамжуулан үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлтийн талаар та бүхэнд үргэлжлүүлэн хүргэж байх болно.

Сургуулийн хичээлийн шинэ жилийг зайн сургалтаар эхлүүлэх болсноос үүдэн зайн сургалтын талаар та бүхэнд чиглэл өгөх, танай хүүхдүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд энэхүү гарын авлага нь туслах болно. Та бүхэн зайн сургалт, нийгэм-сэтгэлзүйн сургалт, сурагчдын хүлээлт, оролцоо, технологийн дэмжлэг туслалцаа болон бусад зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олж авах болно. Бид сурагчдынхаа суралцаж байгаа сургалтын төрлөөс үл хамааран чанартай боловсрол эзэмшүүлэхийг эрмэлзсээр ирсэн билээ. Бид бүх сурагчдаа танхимын болон нийгэм-сэтгэлзүйн сургалт эзэмшүүлэх нөөц бололцоогоор хангаж, тэдний сурч боловсрох, өсч хөгжихөд бүх л талаар дэмжин ажиллах болно.

АУС-ийн удирдлагууд эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, бидний төлөвлөгөөнд үнэлэлт өгч, шаардлагатай бол зохицуулалт хийх мужийн болон тойргийн албаныхантай үргэлжлүүлэн хамтарч ажиллах болно.

Энэхүү гэнэтийн гамшгийн үед хүлээцтэй байж, хамтран ажиллаж байгаа та бүхэндээ баярлалаа.

Хүндэтгэсэн,



Арлингтон Улсын сургуулийн Захирал  
Доктор Франциско Дуран

## АГУУЛГА

СУРГАЛТЫН ТОЙМ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	4
АХЛАХ СУРГУУЛЬ.....	4
ДУНД СУРГУУЛЬ .....	5
ЭХНИЙ САР – ХИЧЭЭЛ ЭХЛЭХ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨНҮҮД .....	6
8 САРЫН 31-9 САРЫН 4: ХИЧЭЭЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ ДОЛОО ХОНОГ.....	6
ХИЧЭЭЛИЙН ЭХНИЙ ӨДӨР: 9 САРЫН 8 .....	7
ЭХНИЙ САР .....	7
ОНЛАЙН ШУУД БОЛОН БИЕ ДААХ СУРГАЛТЫН ХУГАЦАА .....	8
ОНЛАЙН ШУУД СУРГАЛТ .....	8
БИЕ ДААХ СУРГАЛТ .....	9
СУРАГЧДЫН ХҮЛЭЭЛТ .....	10
СОНГОН СУРАЛЦАХ ХИЧЭЭЛҮҮД (ЭРҮҮЛ МЭНД, БТ, УРЛАГ, МТБ) .....	11
НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН СУРГАЛТ (НСС) ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА.....	12
ТАХИР ДУТУУ СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ.....	13
АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ .....	13
АВЬЯАСЛАГ СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ.....	14
ХИЧЭЭЛИЙН ДАРААХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ.....	15
ИРЦ, ОРОЛЦОО.....	16
ҮНЭЛГЭЭ, ДҮН .....	17
ТЕХНОЛОГИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА.....	17
ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН АКАДЕМИ.....	18
ӨӨРИЙН ХҮҮХДЭЭ ДЭМЖИН ТУСЛАХ .....	18
ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ХОСОЛСОН ЗАГВАР РУУ ШИЛЖИХ .....	19
ТҮЛХҮҮР ХОЛБООСУУД.....	19

## СУРГАЛТЫН ТОЙМ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүх ангийн сурагчид Мягмар гаригаас Баасан гариг хүртэл долоо хоногт 4 өдөр синхрон (онлайнаар шууд) болон синхрон бус (бие даах-онлайн эсвэл онлайн бус) сургалтын аль алинд хамрагдах болно. Сурагчид 2020 оны 2 дугаар сард сонгосон хичээлүүддээ суралцах болно.

Даваа гариг бүрт сурагчид онлайн бус сургалтанд хамрагдах бөгөөд хэрэв шаардлагатай гэж үзвэл багш нар хамтын төлөвлөгөөний дагуу зарим сурагчдад зориулан цөөн тооны бүлэг сурагчдад сургалт явуулж болно.

### АХЛАХ СУРГУУЛЬ

Ахлах сургуулийн сурагчдын тусгай танхимын сургалтын хэрэгцээг хангахын тулд өмнөх жилүүдэд суралцаж байсан шиг хичээл тус бүрээр багш нарт зориулан хуваарь гаргана. Зарим сурагчдын сонголтод үндэслэн бие даан суралцах сургалт явуулах шижилт эхлэх үед бүх ахлах ангийн сурагчдын хувьд тэдний сонгосон хичээлээс шалтгаалахгүйгээр нэг багш хичээлийг заах болно. Энэ нь бие даах сургалт руу шилжсэн сурагч тодорхой хичээлээр ангид хичээллэхгүй ч багшаас шууд заавар авах боломжтой гэсэн үг юм. Зайн сургалтыг явуулж байх үед зааж буй хичээлүүдийг өөр нэгэн ажилтан хянаж байх болно.

Хэрэв АУС-ийн багшийн заадаг сургалтанд хамрагдах боломжгүй сурагчдад Виртуал Виржиния зэрэг онлайн хичээл заах үйлчилгээ үзүүлдэг бусад сургалтанд хамрагдах боломжийг санал болгож болох юм.

### АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАГВАР ХУВААРЬ

ДАВАА ГАРИГ БҮРТ	МЯГМАР-БААСАН ГАРИГУУДАД (онлайн шууд болон бие даах сургалт, бүх ангиуд өдөр бүр 5цаг, 35 минут)
<ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөгөө: Ахлах сургуулийн сурагчид сургуулийн ажилтнуудын удирдан явуулдаг онлайн шууд зөвлөлгөөнд хамрагдана.</li> <li>• Багшийн Төлөвлөлт</li> <li>• Хамтарсан Баг (ХБ), анги-түвшин бүрийн эсвэл бусад сурагчдын уулзалт</li> <li>• Багш/Зөвлөхийн Ажлын цаг</li> <li>• Жижиг бүлгээр болон нэг нэгээр оролцох оролцоог чиглүүлэх</li> <li>• Сурагчид бие даах сургалт нэг хичээлд ойролцоогоор 30 мин зарцуулна)</li> <li>• Бие даах НСС хичээл</li> </ul>	1, 2 дугаар үе (нийт 95 минут; онлайн шууд сургалт 50 минут)
	Шилжих хугацаа (5 мин)
	3 дахь үе (нийт 50 мин; онлайн шууд сургалт 30 мин)
	Үдийн хоол (60 мин)
	4, 5 дахь үе (нийт 95 мин; онлайн шууд сургалт 50 мин)
	Шилжих хугацаа (5 мин)
	6, 7 дахь үе (нийт 95 мин; онлайн шууд сургалт 50 мин)

**ДУНД СУРГУУЛЬ**  
**ЗАГВАР ХУВААРЬ**

<b>ДАВАА ГАРИГ БҮРТ</b>	<b>МЯГМАР-БААСАН ГАРИГУУДАД (онлайн шууд болон бие даах сургалт, бүх ангиуд өдөр бүр 5цаг, 35 минут)</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Багшийн Төлөвлөлт</li> <li>• Хамтарсан Баг (ХБ), анги-түвшин бүрийн эсвэл бусад сурагчдын уулзалт</li> <li>• Багш/Зөвлөхийн Ажлын цаг</li> <li>• Жижиг бүлгээр болон нэг нэгээр оролцох оролцоог чиглүүлэх</li> <li>• Сурагчид бие даах сургалтанд хамрагдана (нэг хичээлд ойролцоогоор 30 мин зарцуулна)</li> <li>• Бие даах НСС хичээл</li> </ul>	1, 2 дугаар үе (нийт 89 минут; онлайн шууд сургалт 50 минут)
	Шилжих хугацаа (5 мин)
	3,4 дэх үе (нийт 87 мин; онлайн шууд сургалт 50 мин)
	5 дахь үе (45 мин; онлайн шууд сургалт 30 мин) Багшийн зөвлөгөө (БЗ) (нийт 35 мин)
	Үдийн хоол (50 мин)
	Шилжих хугацаа (4 минут)
	6,7 дох үе (нийт 87 мин; онлайн шууд сургалт 50 мин)

## ЭХНИЙ САР – ХИЧЭЭЛ ЭХЛЭХ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨНҮҮД

### 8 САРЫН 31-9 САРЫН 4: ХИЧЭЭЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ ДОЛОО ХОНОГ

Зайн сургалт нь сурагчид болон тэдний гэр бүлийнхний хувьд шинэлэг сургалт бөгөөд шинэ хичээлийн хуваарь, төлөвлөгөөг ашиглах шаардлагатай юм. Зайн сургалтанд хамрагдах сурагчдад туслах зорилгоор хэд хэдэн алхмуудыг энд орууллаа.

#### ГЭРТЭЭ

- Хэрэв боломжтой бол өөрийн хүүхдийн суралцах орчинг анхаарал бага сарниулах орчноор бүрдүүлэх. Нам гүм орчны хамгийн оновчтой сонголт бол хүүхдүүд сургалтын хэрэглэгдэхүүн, бусад материалуудаа ширээн дээр гарын дор тарааж байрлуулсан ашиглах боломжтой орчин юм.
- Онлайн сургалтын үеэр хүүхэд чинь чихэвчээ ашиглах, ялангуяа та олон хүүхэдтэй бол тэднийг аль болох саад болохгүй байх орчинг бүрдүүлэх
- Хичээлийн эхний өдрөө хүлээж байгаа хүүхэдтэйгээ урвуу тоо тоолж эхлэх
- Өдөр тутмын хуваарь гаргаж, мөрдүүлэх:
  - Хичээл эхлэхээс өмнө өглөөний цайгаа ууж, бүрэн хувцасласан байх.
  - Үдийн хоолны талаар урьдчилан тооцоолорой; хэрэв та АУС-ийн хоол үйлчилгээг ашиглах бол өөрт хамгийн ойр байрлах хоолны газрын байршлыг сонгож, Даваа, Лхагва, Баасан гариг бүр хоол хүргүүлэх төлөвлөгөө гаргана уу.
    - Бага болон дунд сургуулийн сурагчдын үдийн хоолны цаг өдөр бүр 50 минут байна.
    - Ахлах сургуулийн сурагчдын үдийн хоолны цаг өдөр бүр 60 минут байна.
  - Хичээлийн дараа биеийн тамирын дасгал, амрах цаг, хобби зэрэгт цаг зарцуулах төлөвлөгөө гаргаарай.
  - Өдөр бүр хүүхдээ шалгах төлөвлөгөө гаргаарай:
    - Өнөөдөр чи юу сурсан бэ?
    - Өнөөдөр ямар бэрхшээлтэй тулгарсан бэ, маргааш бид яаж үүнийг илүү сайн болгох вэ?
  - Тархины үйл ажиллагааг дэмжих үүднээс шим тэжээлтэй оройн хоол идүүлэхийг хичээгээрэй.
  - Хангалттай нойртой байлгахын тулд тогтсон цагт унтуулаарай.

#### ХИЧЭЭЛД БЭЛЭН БОЛОХ

Хичээл эхлэхээс өмнө танай хүүхдийн сургууль тантай шууд холбогдож, сургууль дээр ирэхийг урьж, холбоо тогтоох мэдээллийг баталгаажуулж, Teams, Canvas гэх мэт аппуудад зориулсан эхний өдрийн зааварчилгааг өгөх болно. Хэрэв танай хүүхдийн багш, эсвэл сургуулиас холбогдоогүй бол та төв байгууллагатай утсаар холбогдоно уу.

Энэ долоо хоногт олон сургуулиуд виртуал нээлт болон сургуульд эргэн суралцахтай холбоотой үйл ажиллагаа явуулах бөгөөд тэрхүү үйл ажиллагааны хуваарийг сургуулийн вебсайтнаас авах эсвэл төв байгууллагатай утсаар холбогдон авна уу.

- Хичээл эхлэх болон дуусах цаг, үдийн хоол, хичээлийн цагийн талаарх хуваарийг нягтлан үзээрэй. Хуваарийг хэвлэн гаргаад хүүхдийн суралцах орчинд нааж тогтоох нь тустай байж болно.

- Хэрэв та хэзээ хичээл эхлэх, хүүхдийнхээ хуваарийн талаар тодорхой мэдэхгүй байгаа бол энэ долоо хоногт сургуультай холбогдоно уу.
  - [Хичээл эхлэх, дуусах тогтсон цагийг](https://apsva.us/school-year-2020-21/school-start-end-times/) АУС-ийн вебсайтад байршуулсан болно.
  - Мөн StudentVUE линкээр орж, хүүхдийнхээ цагийн хуваарийг шалгаж болно.
- Сургалтын хэрэглэгдэхүүн, материалыг сургуулиас авч болох эсэх мэдээллийг хайж олохыг хичээгээрэй.
- Танай хүүхдэд АУС-ийн төхөөрөмж (iPad or Macbook Air) байгаа эсэхийг шалгаад асааж үзээд, нэвтрэн ороорой.
  - Хэрэв та АУС-иас төхөөрөмж аваагүй, эсвэл нэвтрэн орж чадахгүй байгаа бол сургуультай холбогдоорой.
- Хэрэгцээтэй апп руу нэвтрэн орох дадлагыг хийгээрэй.
  - Та сургалтанд хэрэгцээтэй бүх аппуудыг төхөөрөмжиндөө суулгасан байх ёстой.
  - Бага анги: Seesaw, Canvas, Google Classroom, Microsoft Teams
  - Дунд анги: Canvas, Microsoft Teams
- Хүүхдийнхээ АУС-ийн сурагчийн ID дугаар, нууц үгийг мэдэж байх; энэ мэдээлэл нь олон янзын аппууд руу нэвтрэн орох боломжийг олгоно.
- Өөрийн төхөөрөмжийн микрофон, камерийг шалгаад, чихэвчнийхээ ажиллаж байгаа эсэхийг мөн шалгаарай.

### ХИЧЭЭЛИЙН ЭХНИЙ ӨДӨР: 9 САРЫН 8

- Хичээл эхлэхийн өмнөх орой төхөөрөмжөө бүрэн цэнэглээрэй.
- Хүүхдээ эрт босгож, бүрэн хувцасласан эсэхийг шалгаад өглөөний цайг нь уулгаарай.
- Сургуулийн тогтоосон цагт хичээл эхэлнэ-хүүхдийнхээ багшаас авсан хуваарийг шалгаарай.
- Хичээл эхлэхээс дор хаяж 5 минутын өмнө төхөөрөмжөөр Microsoft Teams рүү нэвтрэн ороход хүүхдэдээ туслаарай.
- Хэрэв танд холболтын асуудал тулгарвал зөвлөгөө, нөөц боломжийн талаар [Technology section](#) хэсгээс авна уу.
  - Та хүүхдээ бүртгэсэн эсэхийг баталгаажуулах шаардлагатай бол өглөөний 11 цагаас өмнө сургуультай холбогдон тодруулаарай.
- Хэрэв боломжтой бол хичээлийн эхний өдөр хүүхдээ анги солих, угаалгын өрөө орохоор завсарлах зэрэгт туслах бэлэн төлөвлөгөө гаргасан байх. Дадлага хийснээр илүү хялбар байх болно!

### ЭХНИЙ САР

Хичээлийн эхний хэдэн долоо хоног нь багш, сурагчдад шинэ дэглэм боловсруулж, сургалтын үндэс суурь болсон хүчирхэг хамт олон бий болгох хугацааг өгч байгаа юм. Сурагчид өөрсдийн өвөрмөц байдал, ая тухтай технологийн түвшнээс шалтгаалан олон янзын шатаар өгсөх болно. Баш нар виртуал танхимын хүлээлттэй холбоотой асуултууд асуух, дасан зохицох талаар сурагчдад боломж олгосноор шинэ агуулга нь аажмаар гол хөтөлбөрийн нэг хэсэг болох юм.

Бидний нэн тэргүүнд тавигдсан зорилт бол сурагчдын нийгэм-сэтгэлзүйн хэрэгцээнд тулгуурлан олон нийтийг төлөвшүүлэх, тэднийг суралцахад бэлтгэх явдал юм. Эхний хэдэн

долоо хоногт бид ямар нэгэн бэрхшээлтэй тулгарч болох ч багш, ажилчид боломжтой бүх талаараа бүх сурагчдаа дэмжиж ажиллах үүрэгтэй.

Багш нар, сурагчдын хувьд хичээлийн эхний хэдэн долоо хоногт зайн сургалтын хэмнэл, үйл явцад дасан зохицох хүртэл хүлээцтэй байж, дэмжин туслахыг бид та бүхнээс хүсч байна.

## ОНЛАЙН ШУУД БОЛОН БИЕ ДААХ СУРГАЛТЫН ХУГАЦАА

### ОНЛАЙН ШУУД СУРГАЛТ

Сурагчид өдөрт хамгийн багадаа 3 цагийн онлайн шууд сургалтанд хамрагдана. Бусад сургалтуудыг онлайн бус хэлбэрээр явуулна.

- **Онлайн шууд** сургалт нь харилцан ажиллах, хоёр талт онлайн сургалт бөгөөд виртуал танхимд багштайгаа нэг цагт хамрагддаг.
- **Microsoft Teams** нь видео хуралд зориулагдсан АУС-ийн платформ бөгөөд онлайн шууд сургалтанд ашиглах болно. Багш, сурагч, эцэг эхчүүд Teams платформоор дамжуулан виртуал байдлаар харилцан ажиллах боломжтой болно.

Онлайн шууд сургалт нь хэвлэгдсэн хуваарьт заасан хичээлийн хэсгээс эхлэх болно. Хичээллэх үеэр олон янзын сургалтын форматууд ашиглах болно. Онлайн шууд сургалтын хугацаанд том эсвэл жижиг бүлгээс үл хамааран багш-сурагч шууд харилцан суралцах болно.

Сурагч онлайн шууд сургалтанд хамрагдаж чадаагүй бол багш нар энэ байдлыг засахын тулд хичээлийн танхимд биечлэн уулзах болно. Сурагчид хоцорсон хичээлээ хэрхэн нөхөж авах талаар журмыг багш нарт зориулан гаргах болно. (тухайлбал, Canvas платформ ашиглах талаар сурагчдад чиглэл өгөх). Хоцорсон хичээлээ нөхөж авахад шаардлагатай дэмжлэг түслалцааг ажлын цагаар авч байхыг сурагчдад уриалан дэмжих болно.

### ХИЧЭЭЛҮҮДИЙН БИЧЛЭГ

Багш нар тус тусын бүлгийн онлайн шууд сургалтын хэсгийг (тухайлбал, шинэ агуулгын танилцуулга эсвэл богино хичээл) бичиж оруулаад, нууц үг бүхий хамгаалалттай платформоор (жишээ нь: Canvas гэх мэт) дамжуулан сурагчид ашиглаж болох видео холбоос хийх болно. Сурагчдын хувийн мэдээлэл болон бүртгэл бүрэн болох хүртэл хичээлүүдийн бичлэг хийгдэж болно. Багш нар эдгээр бүртгэлийг нээлттэй болгосноор хичээлдээ суугаагүй эсвэл мэдээлэл үзэх шаардлагатай үедээ сурагчид ашиглах боломжтой болно.

Жил бүрийн онлайн баталгаажуулалтын үйл явц (ЖБОБҮЯ) эхлэх үед гэр бүлүүд хүүхдийнхээ сургалтын бичлэг хийлгэх үйлдлээс татгалзаж болно. Хэрэв тухайн гэр бүл ЖБОБҮЯ -ийн бүртгэл явагдах хугацаанд татгалзаж чадаагүй бол хүүхдийнхээ сургалтын бичлэг хийх талаар татгалзсан хүсэлтээ хэзээ ч бичгээр гаргаж өгч болно.

***Сургалтын видео бичлэгийг зөвхөн сурагчдын боловсролын хэрэгцээнд зориулах зорилгоор ашигладаг тул бусадтай хуваалцаж болохгүй гэдгийг эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.***



## БИЕ ДААХ СУРГАЛТ

- **Бие даах** сургалтын төрөл нь олон янз байдаг. Видео хэлбэрээр бичсэн хичээлүүд, онлайн үйл ажиллагаанууд, эсвэл онлайн бус даалгаврууд бүхий материалууд, даалгаврууд, өгөгдсөн даалгавруудыг сурагчдын хүртээл болгох боломжтой юм.
- Бусад сурагчид, багш нартайгаа харилцан ажиллахдаа олон янзын формат (жишээ нь: хэлэлцүүлгийн самбар, өгөгдсөн даалгавар гэх мэт) ашиглах боломжтой юм.
- **Бие даах** сургалтаар сурагчид өөрсдийн төхөөрөмж дээр эсвэл онлайн бус хэлбэрээр даалгавраа гүйцэтгэх боломжтой юм.
- **Бие даах** сургалтын үед багш нар сургалтын талаар заавар өгч, материалаа засварлах, сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Эдгээр дэмжлэг туслалцаанд сурагчидтайгаа эргэх холбоо үүсгэх, тодруулга хийх, цахим шуудан илгээх үйл ажиллагаанууд орно.
- **Бие даах** сургалт нь суралцагчдын цагийн хуваарьт нийцсэн уян хатан, бие даан суралцахад тохирсон, өгөгдсөн даалгаврыг хийж дуусгах хүртэл нь хүлээж байх ёстой.

Бие даах сургалтаар сурагч хичээлийг ойролцоогоор 30-45 минут хийнэ. Сурагчдыг төхөөрөмжөөс аль болох хол байлгах зорилгоор бие даан гүйцэтгэх даалгаврыг олон янзын форматаар боловсруулдаг. Сурагчид материалуудаа хэвлэн гаргах шаардлагагүй юм.

## ГЭРИЙН ДААЛГАВАР

AP, DE болон IB ангийн сурагчдаас гадна бие даах сургалтын үед сурагчийн өдөр бүр тогтсон хичээлийн хугацаанаас гадна нэмэлт даалгавар/гэрийн даалгавар өгөхгүй. AP, DE болон IB ангийн сурагчдын хувьд бие даах сургалтаас гадна нэмэлт даалгавар авснаар коллежийн түвшний хичээлийн бүрэн хөтөлбөрт хамрагдах боломжтой болно.

## СУРАГЧДЫН ХҮЛЭЭЛТ

Бүх сурагчдаас сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаа болох виртуал ангид байх үедээ өдөр бүр хичээл эхлэхээс өмнө болон дараа нь биеэ зүй зохистой авч явах, үүрэг хариуцлагаа ухамсарлах, бусдыг хүндэтгэх, сахилга баттай байхыг хүсч байгаа болно.

Зайн сургалтын үеэр сурагчдаас хүлээж байгаа хүлээлт бол:

- Хичээл бүрт оролцох, онлайн үйл ажиллагаанд хамрагдах, идэвхтэй сурч боловсроход хүчин чармайлт гарган өөрийгөө дайчлах.
- Тогтоосон хугацаанд өгөгдсөн даалгавруудыг бие даан, эсвэл зохих ёсны дагуу эцэг эхийн тусламжтайгаар гүйцэтгэх.
- Багш нарын заавраар зайнаас үнэлгээ (тест) хийлгэх.
- Өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэх явцад гарч болох аливаа зөрчил (өвдөх, ажиллах, ах дүүсээ асран халамжлах зэрэг) гарах үед багш нартайгаа харилцан холбогдох.
- АУС-иас өгсөн төхөөрөмжөө ариг гамтай хэрэглэх, АУС-иас гарсан бодлого, удирдамжийн дагуу онлайнаар харилцан холбогдох.

Онлайнаар сурч байгаа сурагчдын гүйцэтгэх ёстой үүрэг:

- Хичээлд идэвхтэй, чөлөөтэй оролцох.
- Хичээлд оролцохдоо зүй зохистой хувцаслах, Microsoft Teams платформын дэвсгэрийн өнгийг (бүдэг эсвэл өөр дэвсгэр сонгосон байх) тохируулсан байх.
- Microsoft Teams уулзалтын (онлайн шууд сургалтын заавар) үеэр багшийнхаа заавраар камераа ажиллуулах; сургуулийн ажилтнуудад сурагчдад/эцэг эхчүүдэд камерыг унтрааж, асаах уян хатан боломжийг олгох болно.
- Яриагүй үедээ микрофоныхоо дууг хаах.
- Хэрэв хичээлийн үед асуулт асуух бол Microsoft Teams платформын “гараа өргөсөн” тэмдэглэгээг ашиглах.
- Өөрсдийнхөө болон бусад сурагчдын анхаарлыг сарниулах байдал гаргахгүй байх (ТВ ашиглахгүй, гэр бүлийн гишүүдтэйгээ харицан ярилцахгүй гэр мэт.)
- Бүх виртуал харилцааны туршид хэл яриагаа зохистой хэрэглэх. Харилцааны (жишээлбэл, цахим шуудан, хэлэлцүүлгийн самбар, бүлгийн төсөл, ирүүлсэн даалгавар гэх мэт) ямар ч хэлбэрийн үед доромжилсон эсвэл зохисгүй үг хэллэг ашиглахыг хориглоно.
- Бие биетэйгээ болон багш нартайгаа эелдэг, хүндэтгэлтэй харьцах. Аюулгүй онлайн орчинд сурагчид өөрсдийгөө бие даасан нэг анги мэт илэрхийлэн гаргах эрхтэй.
- Онлайнаар зохисгүй харилцаа холбоо үүсэн гарсан тохиолдолд багш нар/сургуулийн захиргаанд нэн даруй мэдэгдэх.
- Canvas болон Microsoft Teams профайл дээрээ өөрсдийнхөө [зураг эсвэл bitmoji нэмж оруулах](#).

Зайн сургалтын үеэр сурагчид АУС-ийн бүх дүрэм журмыг мөрдөж, биеэ авч явах ёстой бөгөөд АУС-ийн сахилгын батын журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. АУС-ийн гарын авлагын зан үйл ба сахилгын хариуцлагын талаар [APS Handbook \(apsva.us/wp-content/uploads/2020/08/Handbook2020-21-distance.pdf\)](https://apsva.us/wp-content/uploads/2020/08/Handbook2020-21-distance.pdf) сайтаас үзнэ үү.

## СОНГОН СУРАЛЦАХ ХИЧЭЭЛҮҮД (ЭРҮҮЛ МЭНД, БТ, УРЛАГ, МТБ)

### ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР (БТ)

Сурагчид:

- Онлайн шууд болон онлайн бус сургалтын загварыг ашиглан шинэ агуулгаар суралцах
- Харилцаа холбоо бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцох
- Бие бялдрын ур чадварыг хөгжлөө хөгжүүлэх, харуулах
- Өөрийн түвшинд тохирсон бие бялдраа хөгжүүлэх зорилгодоо хүрэхийн тулд бие бялдрын дасгал хийх
- Эрүүл шийдвэр гаргахын тулд эрүүл саруул байх чадвараа хөгжүүлэх, түүнийг ухамсарлан ойлгох
- Үр өгөөжтэй харилцаа холбоо, стресс менежмент, нийгэм-сэтгэлзүйн сургалт, харилцаа холбоог бий болгох стратегийг эзэмшиж, дадал болгох.

### УРЛАГ, ЕРӨНХИЙ ХӨГЖИМ, ХӨГЖМИЙН ЗЭМСГҮҮД

- Сурагчид онлайн шууд болон онлайн бус сургалтын аль алиныг ашиглан шинэ агуулгаар суралцах болно.
- Сурагчид дүрслэх урлагийн үзэл баримтлал болон хөгжил, хөгжмийн бичиг үсэгт бэлтгэх, ноот, хэмнэл уншихын тулд хичээлийн агуулга болон хэрэглэгдэхүүнээр Canvas, Seesaw зэрэг платформуудыг ашиглан онцгойлон анхаарч суралцах болно.
- Flipgrid нь сурагчдад ангийнхантайгаа болон багш нартайгаа нийгмийн болон сэтгэл зүйн холбоо тогтоох видео хэлбэрээр бусадтай харилцан холбогдох, онлайн шууд сургалтаас онлайн бус сургалтын загвар руу шилжих боломжийг олгох юм.
- Хөгжмийн зэмсэгтэй суралцаж буй бүх сурагчид харилцан холбогдох онлайн сургалтын арга зүйн номоор хангагдаж, видео болон аудио бичлэгээр даалгавраа хамтарч эсвэл ганцаараа хийх чадвар эзэмших, багш нартайгаа ганцаарчлан эргэх холбоо үүсгэн нэн даруй эргэн холбогдох боломжийн аль алинаар хангагдах болно.
- Хөгжмийн зэмсгүүдийг сургууль дээр тарааж өгнө.

Сурагчдын зайн сургалтаар сурч байх үед АУС-ийн хөгжим, урлагт зориулсан бидний нийтлэг хүсэл тэмүүлэл, сониуч байдал маань биднийг нэгдмэл хамт олон хэвээр байлгах болно.

### МЭРГЭЖИЛ БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ (МТБ)

Мэргэжлийн болон Техникийн Боловсрол (МТБ)-ын цогцолбор ахлах сургууль болон бусад хөтөлбөрүүдийн бүх сургалтыг Мэргэжил олгох Төвийн 2020-2021 оны сургалтын хөтөлбөрийн дагуу явуулна. Бүтэн зайн сургалтын үеэр Мэргэжил олгох Төв (Academic Academy, Arlington Tech, English Learner Institute, PER) -д бүрэн цагийн хөтөлбөрт хамрагдсан сурагчид, зайн сургалтаар Мэргэжил олгох төвийн багш нарын санал болгосноор цогцолбор ахлах сургууль болон бусад хөтөлбөрт сурагчид хамрагдах боломжтой.

Мэргэжлийн болон Техникийн Боловсрол (МТБ) сургалтын бүх сурагчид онлайн шууд болон бие даах сургалтын аль алиныг ашиглан бүх МТБ-ын хэсэгчилсэн шинэ агуулга бүхий хөтөлбөрт хамрагдах боломжтой.

- Сурагчид МТБ-ын хөтөлбөрт нийцүүлэн сургалтанд хамрагдах болно.

- Сургалтын заавар өгөхөд туслах зорилгоор өдөр тутам форматив үнэлгээ хийгдэнэ.
- Сурагчид хичээлийн нэг онцлог агуулга болох лабораторид дадлага хийнэ.
- Ажлын байртай болох чадварыг виртуал сургалтын загвараар эзэмшинэ.
- Хэрэгцээт, шаардлагатай багаж хэрэгсэл бүхий МТБ-ын тусгай иж бүрдэл хэрэгслээр хангана.
- Зайн сургалтын чанарыг сайжруулах зорилгоор зарим сургалтанд виртуал хэрэгслийг ашиглах болно.
- Энэ хичээлийн жилд зайн сургалтаар болон зөвшөөрөгдсөн тестийн төвүүдээс гэрчилгээ олгох зарим боломжийг олгоно.

МТБ-ын алба болон багш нар АУС-ийн бүх сурагчдаа чанартай, сонирхол татсан зайн сургалтанд хамруулахыг зорьж байгаа болно.

## НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН СУРГАЛТ (НСС) ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА

Олон сурагчид энэхүү цар тахлын үеэр ямар нэгэн шокод орсон байж болох бөгөөд зарим нь сэтгэлийн дарамтанд орж, бага байхдаа тохиолдсон сэтгэлийн шархаа эргэн санадаг болохыг бид мэднэ. Энэхүү гэнэтийн гамшгийн үеийн хичээлийн шинэ жилийг танхимын шинэ сургалтад шилжүүлэхийн тулд сурагчдын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэх үүднээс хангалттай цаг хугацаатайгаар бид эхлүүлэх ёстой. Нийгэм-сэтгэлзүйн сургалт (НСС) нь суралцах чухал үндэс суурь бөгөөд хичээлийн жилийн туршид бүх сурагчдад зориулан долоо хоногийн хуваарьт багтаасан болно.

6-12 дугаар ангийн сурагчдад НСС нь долоо хоногт 30 минут орно.

**Ахлах сургууль:** Даваа гариг бүрийн онлайнгаар шууд өгөх бүх зөвлөгөөнд ахлах сургуулийн НСС-ын хөтөлбөрийн Эрч хүчний эх үүсвэр сэдвийг ашиглан урьдчилан бичсэн зөвлөхийн видео хальсанд хураасан хичээлүүдийг шинжлэн, судлах болно.

**Дунд сургууль:** Даваа гариг бүрт урьдчилан бичсэн НСС-ын хичээлүүдийг багш нар сурагчдаар судлуулах болно. Үзсэн хичээлүүдээ бататган, дадлага болгон ашиглаж болох HomeLinks үйл ажиллагааг танай гэр бүл гэртээ хийж болно.

Сургуулийн ажилтнууд долоо хоног бүрийн Багш нарын Зөвлөгөө (БЗ)-нд оролцох үед сурагчийн нийгэм, сэтгэлзүйн байдал хэр сайн байгааг үнэлж байх болно. Шууд утсаар болон бусад сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг Canvas ашиглан сурагчид хялбархан авах боломжтой болно.

Нэмэлт онлайн шууд хичээлүүдийн зөвлөгөө авах хугацаанд болон багш нарт зориулсан урьдчилсан хуваарийн дагуу явуулах бөгөөд дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх, мансууруулах бодис хэрэглэх, коллеж болон мэргэжлийн бэлтгэл, цагийн хуваарь зэрэг сэдвүүдээр хичээл оруулах болно.

Зөвлөхүүд өдөр бүр ажлын цагаар ажиллаж, товлосон хуваарийн дагуу сурагчид болон эцэг эхчүүдтэй уулзах болно.

## ТАХИР ДУТУУ СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Багш нар Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (ГБХ) эсвэл Зүйл 504 Төлөвлөгөөг хянан үзсэнээр зайн сургалтын загвараар тухайн боловсролын үйлчилгээ, аргачлалыг хэрэгжүүлэх боломжтой юм. Тусгай боловсролын багш нар, сургагч багш нар нь анги удирдсан багш нар болон Сургалтын Хамтарсан Баг (СХБ)-ийнхантай хамтран дэмжлэг түслалцааг үзүүлэхдээ анхааралтай төлөвлөж, хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах болно.

Виртуал сургалтанд ашиглаж болох зарим нийтлэг аргачлууд байдаг. Үүнд:

- Бичмэл материалууд болон дуу бичлэгийн тусламжтай сургалтыг явуулах
- Бүх тэмдэглэл, тараах материалуудыг хувиан өгөх
- Сурагчдад сургалтын агуулгыг аажмаар ойгуулах, хугацааг уртасгаж өгөх
- Сурагчийн хамгийн амжилттай гүйцэтсэн форматаар үнэлгээ (тест) өгөх
- Өгөгдсөн даалгаврыг биелүүлэхийн тулд өөр нэмэлт аргачлал ашиглах боломжийг сурагчдад олгох
- Даалгавар болон өгөгдсөн даалгаврыг биелүүлэх сонголтыг сурагчдад өгөх, өгөгдсөн агуулгыг олон янзын аргаар үнэлэн дүгнэх.

ГХБ-тай хамтран ажиллах нэмэлт зөвлөмжүүдийг [Special Education Supports and Services: Fall, 2020 Guidance for Families \(apsva.us/special-education/fall-2020-special-education-information-for-families-8-25-20/\)](https://apsva.us/special-education/fall-2020-special-education-information-for-families-8-25-20/) сайтад зочлон авна уу.

## АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Дунд сургуулийн Англи хэл суралцагчид (АХС) зайн сургалтын орчинд Англи хэлний Хөгжил (АХХ)-ийн дамжаагаар дамжуулан суралцах болно. Сургалтын агуулгад нийцсэн Англи хэлний хөгжилд анхааран онлайн шууд сургалтын тусгай цагаар сургалт явагдана. Өөрөөр хэлбэл, сурагчдын хувьд шинэ чадвараа дээшлүүлэх, шинэ агуулгаар ажиллах бие даах сургалтанд хамрагдах юм. Зайн сургалтын үеэр Англи хэлний багш нар сургалтыг том болон жижиг бүлэг, заримдаа ганцаарчилсан байдлаар явуулах болно. Анхаарах гол асуудал бол сурагчийн хэлний гол дөрвөн чадвар (үнших, бичих, ярих, сонсох) -ыг хөгжүүлэхээс гадна сургалтын агуулгын тодорхой хэсэг (тухайлбал, Англи хэлний урлаг, шинжлэх ухаан, нийгэм судлал гэх мэт) эзэмшүүлэх юм.

Дунд ангийн Англи хэлний багш нар, ялангуяа Англи хэл суралцагчид зайн сургалтын хамгийн шилдэг дадлага сургалтанд тухайн урьдчилсан үйлчилгээний шаардлагаар долоо хоногийн турш хамрагдсан юм.

- Онлайн шууд сургалтын үед зохих хэл яриа, зорилгод нийцсэн агуулгаар сургалтыг явуулна. Мөн сурагчдад Англи хэлний чадвараа ашиглан дадлага хийх хугацаа өгөх болно.
- Дунд ангийн Англи хэл суралцагчдад зориулсан зайн сургалтын загварууд:
  - Зайн сургалтын Англи хэлний хөгжил – Англи хэл суралцагчид зайн сургалтыг мэргэжлийн Англи хэлний багшаар заалгана. Сургалтаар Англи хэлний хөгжил болон агуулгын (тухайлбал, Англи хэлний Урлаг, Шинжлэх ухаан гэх мэт.) аль алинд анхаарах болно.

- Зайн сургалтаар хамт заах хичээлийн агуулга – Англи хэл суралцагчид Англи хэлний багш болон агуулгын багштай хамт ерөнхий боловсролын зайн сургалтанд хамрагдана. Англи хэлний багш нар сурагчдын Англи хэлний хөгжилд, агуулгын багш нар агуулгад анхааран сургалтыг явуулна.
- Бүх багш нар хичээлийн агуулга, хэлний хөгжилд анхааран сургалтыг үргэлжлүүлэн явуулахын тулд агуулга, хичээлийн зорилгуудыг ашиглах болно.
- Анги хэлний зөвлөхүүд дунд сургуулийн Англи хэл суралцагчдын нийгэм-сэтгэлзүйг хэвийн байлгах талаар анхаарч ажиллана. Тэд шоконд орсон, биеэ зүй бус авч явдаг, шинээр ирсэн, эсвэл бусад асуудалтай байдал нь тэдэнд нөлөөлж, танхимын сургалтанд сөргөөр нөлөөлдөг Англи хэл суралцагчидтай ажиллах болно.

## АВЪЯАСЛАГ СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Авьяаслаг суралцагчдад зориулсан сургалтыг ялгаатай байдлаар заах АУС-ийн загвар нь “хамтарсан бүлэг” бөгөөд бидний баталсан орон нутгийн төлөвлөгөөг удирдамж болгодог. Авьяаслаг сурагчдыг онцлон нэг бүлэг болгож, илүү үр дүнтэй төлөвлөлт, ялгаатай сургалтанд хамруулахын тулд Авьяастнуудын Нөөц Багш нар (АНБ) долоо хоног бүр дасгалжуулж, дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Энэ нь үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах сурагчдыг дэмжин туслах бүтцийг бий болгох боломжийг олгодог.

Багш нар, эрчимжүүлсэн/AP/IB ангийн багш нар, Авьяастнуудын Нөөц Багш нар (АНБ) бүгд хамтран, авьяаслаг сурагчдын танин мэдэхүйн болон нийгэм-сэтгэлзүйн өвөрмөц хэрэгцээг хангахын тулд эмзэг сэтгэлгээг дэмжихэд чиглэсэн урамшуулан дэмжих сургалтын хөтөлбөрийг гаргах болно.

Авьяастнуудын Нөөц Багш нар нь дунд сургуулийн бүлгийн багш нарт болон ахлах сургуулийн эрчимжсэн /AP/IB ангийн багш нарт байнгын дэмжлэг, дасгалжуулалтыг үргэлжлүүлэн өгч байх болно. Тэд мөн агуулгын товчооны дэмжлэгтэйгээр авьяаслаг оюутнуудад зориулан бичсэн АУС-ийн Шүүмжлэгч болон Бүтээлч Сэтгэлгээний Үндэс/ эсвэл нөөцийн үндэсний талаарх сургалтын хөтөлбөрийг ашиглан сургалтын төлөвлөгөөнд дэмжлэг тусалцаа үзүүлэх болно.

Энэхүү баримт бичиг дурьдсан Тусгай Боловсролд зориулсан сургалтаас Хүлээлт хүсч буй хоёр удаагийн онцгой (2e) суралцагчдад зориулан төлөвлөгөө гаргаж, дэмжлэг үзүүлэхийн тулд АНБ нар тусгай боловсролын сургагч багш нар болон багш нартай үргэлжлүүлэн хамтран ажиллах болно. Боломжтой гэж үзвэл АНБ нар нь ГБХ болон 504 төлөвлөгөөний үйл явцын нэг хэсэг байх болно.

АНБ нар ахисан түвшний/авьяаслаг болон нэмэлт хэрэгцээ шаардлагатай сурагчдыг дэмжин туслахын тулд Англи хэлний багш нартай хамтран ажиллах болно.

## ХИЧЭЭЛИЙН ДАРААХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Зайн сургалтын үеийн клуб, үйл ажиллагаа, хөнгөн атлетикийн талаарх мэдээллийг Эцэг эхчүүдийн Академийн видеог ([youtube.com/watch?v=4s2qyclPAbo](https://youtube.com/watch?v=4s2qyclPAbo)) холбоосоор орж үзнэ үү. Илүү их мэдээлэл тавигдах бүрт видеонууд шинэчлэгдэх болно.

COVID-ийн удирдамжийн дагуу АУС нь аливаа үйл ажиллагаа, хөнгөн атлетикийн спортыг захирагчийн удирдамж, Виржиния мужийн Боловсролын Газар, Виржиния мужийн Эрүүл Мэндийн Газрын арга хэмжээтэй уялдуулан явуулах болно.

### ХӨНГӨН АТЛТИК

#### АХЛАХ СУРГУУЛИЙН ХӨНГӨН АТЛТИК

АУС нь өнгөрсөн зуны улиралд намрын спортын улирлын бус дасгал сургуулилтаа амжилттай явуулсан бөгөөд бүх гурван цогцолбор ахлах сургуулийн оролцоо өндөр түвшинд хүрсэн байсан. Анх сурагч болсон сурагч тамирчдын хувьд виртуал танхимын сургалтаа амжилттай эхлүүлэхийн тулд 8-р сарын 21-нд эдгээр бэлтгэл сургуулилыг хичээлийн эхний сард түр зогсоосон болно. Сурагч тамирчид хичээлдээ анхаарлаа төвлөрүүлэхийн зэрэгцээ дасгалжуулагчдынхаа зааж сургасан дасгал хөдөлгөөнийг гэртээ хийснээр чийрэгжих боломжтой.

АУС нь сурагч тамирчдын бие бялдрын чийрэгжүүлэхийн тулд спортын бүх төрлүүдийн сургалтыг 10-р сарын эхээр сэргээж, сурагч тамирчиддаа зориулан дасгалжуулагч болон бусад итгэмжлэгдсэн насанд хүрэгчидтэй холбоо тогтоож, нийгэм, сэтгэлзүйн хувьд нэн шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх болно гэж найдаж байна. Энэ зуны амжилт, аюулгүй байдалд авсан арга хэмжээний дагуу дахин явуулах бол бүх сургалт гадна явагдах болно.

Одоогоор зайн сургалтанд хамрагдах сурагчид хосолсон/ бие даах сургалт руу шилжсэний дараа бие даах спорт болон бусад үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаар шийдвэр гараагүй байна.

#### ДУНД СУРГУУЛИЙН ХӨНГӨН АТЛТИК

Одоогийн байдлаар дунд сургуулийн хөнгөн атлетикийн мэдээлэл бөгөөд энэ талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг энэ намрын сүүлээр өгөх болно.

#### КЛУБУУД, БУСАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

АУС- нь бүх сурагчдад нээлттэй олон клубтэй бөгөөд олон үйл ажиллагаа явуулдаг. Клубын гишүүн байх нь хичээлийн бус цагаар үе тэнгийнхэнтэйгээ харилцаа холбоогоо бэхжүүлэн, өргөжүүлэх гайхалтай арга бөгөөд сурагчдын зөвлөл, Оюун санааны Одиссей, жил бүрийн товхимол, сайн найзууд, ширээний тоглоом, мэтгэлцээн, технологи гэх мэт олон янзын үйл ажиллагааг сурагчдад санал болгодог юм. Эдгээр боломжууд нь сурагчдыг танхимын сургалтаас гадна өөр бусад зүйл сонирхох чадварыг олгодог.

Эцэг эхчүүд клуб болон тэдгээрийн төрөл, үйл ажиллагааны талаар хүүхдийнхээ сургуулийн вэб сайтнаас шалган мэдэх хэрэгтэй. Эдгээр клубуудын веб сайт дээр виртуал уулзалтын өдөр, цаг, ивээн тэтгэгчидтэй холбоо барих мэдээлэл мөн байх ёстой.

## ИРЦ, ОРОЛЦОО

Виржиниягийн Боловсролын хэлтэс (ВБХ) -ээс өдөр бүр хичээлд оролцохыг шаарддаг. “Ирц” -ийг тооцуулахын тулд сурагчид багшийн заасны дагуу багш нарыг “харилцан ярихаар холбогдох” үед хариулж, харилцаж байх ёстой. Үүнд онлайн судалгааны асуулт (тухайлбал, гарах билет, НСС видео асуулт гэх мэт) эсвэл чат бичин оролцож болно.

Ирц нь өгөгдсөн даалгаврыг биелүүлэхтэй холбоогүй болно. Манай сурагчдын Synergy Мэдээллийн Системд ирцийг баталгаажуулна. Хэрэв сурагч тухайн өдөр бүртгүүлээгүй бол тасалсан гэж үзээд бол гэр бүлтэй нь холбогдох болно.

### ӨДӨР ТУТМЫН ИРЦ

Өдөр бүрийн бүртгэл, Даваа-Баасан гаригуудад:

- Сурагчид “Гэр өрөө/БЗ үе” Даваа-Баасан гаригт өдөр тутмын хичээлд 16 цаг гэхэд бүртгүүлсэн байх ёстой.
- Энэ тэдний өдөржин суралцсаныг илтгэж байгаа болно. Сурагч хэрэв бүртгүүлээгүй бол тасалсан гэж тэмдэглэгдэх болно.
- Сурагчдад холболтын асуудал тулгарвал өглөөний 11 цагаас хожимдолгүйгээр сургуулийн ирцийн шууд утсаар мэдэгдэх ёстой.
- Хэрэв сурагч өвчтэй байснаас бүртгүүлж чадаагүй бол эцэг эхчүүд нь сургуулийн ирцийн алба руу цахим шуудан бичих эсвэл утсаар мэдэгдэж болно.
- Ирцийн утасны дуудлагын цаг 19 цагт дуусна.

### ОРОЛЦОХ ХУГАЦАА

Synergy платформд оролцооны хугацааг баримтжуулан тавина. Багш нар ирцийн хугацааг хянахын тулд дараахь аргуудын аль нэгийг ашиглах болно. Үүнд:

- Онлайн маягт, асуулт, судалгаа (тухайлбал, гарах билет, НСС видео асуулт гэх мэт)
- Чат бичиж оролцох (багштай шууд эсвэл багшийн үүсгэсэн бүлгийн чатаар)
- Багш сурагчтай утсаар ярих (ялангуяа энэ нь холболтын асуудалтай сурагчид хамаарна)
- Хичээлтэй холбоотойгоор MS Team уулзалтад оролцох

Хичээл тасалсан, ирц бүртгэлийн талаар дэлгэрэнг мэдлээл авах бол [APS Handbook \(apsva.us/wp-content/uploads/2020/08/Handbook2020-21-distance.pdf\)](https://apsva.us/wp-content/uploads/2020/08/Handbook2020-21-distance.pdf) хаягаар орж үзнэ үү.



## ҮНЭЛГЭЭ, ДҮН

Багш нар өөрсдийн дүгнэлт, тогтсон үнэлгээнд үндэслэн гаргасан сурагчдын үнэлгээг 9 сар гэхэд бэлэн болгосон байна. Бүтэн жилийн турш сурагчдын эзэмшсэн стандарт, чадвар, ахиц дэвшлийг шалган тогтоох янз бүрийн үнэлгээг ашиглах болно. Сургалтыг байнга үнэлэхийн тулд Тоон үнэлгээний хэрэгслүүд (тухайлбал, Canvas Quizzes, Google Forms гэх мэт)-ийг ашиглах болно.

Хичээлийн сэдэв дуусах бүрт сурагчдын мэдлэгийн түвшинг шалгахад эцсийн үнэлгээг (жишээ нь: төсөл, тест, эссэ гэх мэт) ашиглана. Сургалтын гол стандартууд ба зорилтуудын үр дүнд хүрэхийн тулд сурагчид цаг тухай бүр, ач холбогдолтойгоор эргэн холбогдож байх боломжтой юм.

АУС-ийн бодлогын дагуу баримталдаг бага сургуулийн дүнгийн талаар [Policy Implementation Procedure I-7.2.3.34 PIP-1](#) сайтнаас авна уу.

## ТЕХНОЛОГИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА

Дунд сургуулийн бүх сурагчдад iPad, ахлах сургуулийн сурагчдад Macbook Air өгөх болно. Гэртээ интернет холболтгүй сурагчдыг hotspot ашиглан утасныхаа MiFi-аар орохыг эсвэл АУС-ийн түнш Comcast (илүү дэлгэрэнгүйг: [apsva.us/internet-service/](https://apsva.us/internet-service/) авна уу) -аар холбогдон ороорой. Эдгээр төхөөрөмжүүдийг сургуулиасаа авч болно.

Хэрэв сурагчид төхөөрөмж эсвэл интернетийн холболттой холбоотой асуудалтай тулгарвал:

- Тасарсан хичээл/агуулгын талаар багштайгаа холбогдон тодруулах эсвэл цахим шүүдэн илгээх (хэрэв тэд боломжтой бол).
- Техникийн тусламжийн талаар сургуулийн веб сайтнаас шалгах, сургуулийн Сургалтын Технологийн Зохицуулагч (ITC)-аас зөвлөгөө авах.
- Хэрэв асуудал гарвал дараахь эх үүсвэрүүдийг ашиглана уу:
  - Сургуулийн веб сайт
  - [APS distance learning webpage \(apsva.us/school-year-2020-21/technical-support/\)](https://apsva.us/school-year-2020-21/technical-support/)
  - [iPad resources \(apsva.us/ms-student-technology-tutorials/\)](https://apsva.us/ms-student-technology-tutorials/)
- [school's tech help form \(apsva.us/digital-learning/contact-itc/\)](https://apsva.us/digital-learning/contact-itc/) -ийг ашиглан асуудлаа шийдүүлэх.

## ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН АКАДЕМИ

АУС нь [APS Parent Academy \(parentacademy.apsva.us\)](https://parentacademy.apsva.us) сайтаар дамжуулан зайн сургалтын талаарх зөвлөгөө, хангамжийг гэр бүлд өгдөг. Эцэг Эхчүүдийн Академид зайн сургалтын үйл явцыг ойлгоход туслах, сурагчдын дадлагыг оновчтой болгоход туслах үүднээс урьдчилан бичсэн хичээлүүд, видео хичээлүүд болон нэмэлт эх сурвалжуудын цувралууд багтсан байдаг. Видео бичлэгүүд болон эх сурвалжуудад АУС-ийн сургагч багш нараас өгсөн зайн сургалтын талаар мэдээлэл багтах бөгөөд дараахь асуултуудад хариулах болно. Үүнд:



- Өөрийн хүүхдээ хэрхэн дэмжин туслах тухай болон Microsoft Teams-ийг ашиглан гэртээ амжилттай суралцах орчинг бүрдүүлэх тухай зөвлөгөөнүүд
- Teams, Canvas, Seesaw програмыг хэрхэн ашиглах, нэвтрэн орох
- Хөгжлийн бэрхшээлтэй, Англи хэл суралцагч, авьяаслаг сурагчдад зориулсан түсгэй үйлчилгээ, дэмжлэгийг хэрхэн хүртэх
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөнгөн атлетикаас хүлээж буй хүлээлт
- Зайн сургалтын загваруудын хэсэг болох Дэвшилтэт Байр Суурь (ДБС), Олон Улсын Бакалавр (ОУБ), Давхар элсэлтийн сургалтуудын талаархи мэдээлэл

АУС нь бүтэн жилийн туршид шинэ курс нэмэх, харилцан холбогдох хурал зохион байгуулах, бусад форматын нөөц хангамжийг үргэлжлүүлэн нэмсээр байх болно.

### ӨӨРИЙН ХҮҮХДЭЭ ДЭМЖИН ТУСЛАХ

Зайн сургалтанд зориулан хүүхдээ хэрхэн бэлтгэх талаар зарим зөвлөмжүүдийг доор оруулав.

- Хүүхэддээ өдөр тутмын хэвшлийг бий болгож, цагийн хуваарь баримтлахад нь туслах.
- Хүүхэд тань сурахад тухтай байх газрыг хайж олох. Хамгийн оновчтой сонголт бол хүүхдүүд сургалтын хэрэглэгдэхүүн, бусад материалуудаа ширээн дээр гарын дор тарааж байрлуулан ашиглах боломжтой орчин юм.
- Биеийн тамир, дасгал хөдөлгөөн хийх завсарлага өгч урамшуулах.
- Canvas эсвэл ParentVue ашиглан хүүхдийнхээ хийсэн зүйлийг шалгах
- Хүүхэддээ нэмэлт эх хангамжийн хэрэгцээ, дэмжлэг хэрэгтэй гэж үзвэл хүүхдийнхээ багш, сургуулийн зөвлөх эсвэл администратортой холбогдоно уу.

## ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ХОСОЛСОН ЗАГВАР РУУ ШИЛЖИХ

Эрүүл мэнд, аюулгүй байдал, бие даан суралцах хэлбэрт шилжих бэлтгэл нь бидний гол анхаарлын төвд байсаар байгаа бөгөөд сургуульдаа эргэн суралцах төлөвлөгөөний цөм хэвээр байгаа билээ. АУС-д CDC, Виржиния мужийн Эрүүл мэндийн Хэлтэс, Арлингтон мужийн Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн удирдамжид үндэслэсэн эрүүл, аюулгүй байдлын тогтсон, цогц төлөвлөгөө байдаг. Дэлгэрэнгүйг [health and safety information is available on the APS website \(apsva.us/school-year-2020-21/transition-to-hybrid-in-person-model/\)](https://apsva.us/school-year-2020-21/transition-to-hybrid-in-person-model/) авна уу.

АУС нь эрүүл мэндийн мэдээллийг хянах, бие даах сургалт болон хосолсон үеийн боломжуудыг үнэлэх талаар бие даан зааварчилгаа өгөх боломжийг үнэлэх асуудалд муж улсын эрүүл мэндийн ажилтнууд болон Арлингтон мужийн Нийгмийн эрүүл мэндийн хэлтэстэй нягт холбоотой хэвээр ажиллаж байна. Энэхүү шилжилтийг эхлүүлэх нь аюулгүй гэж үзвэл бид хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулах бие даах сургалтыг нэн тэргүүнд тавьж, дараа нь СӨБ-3 ангийн сурагчид болон Англи хэл суралцагчдыг хамруулах болно. Бид эрүүл мэндийн мэдээлэл, эрүүл мэндийн ажилтнуудын удирдамжид үндэслэн бие даах хосолсон загварыг сонгосон бүх гэр бүлүүдийг шилжүүлэх ажилд анхаарлаа хандуулан ажиллах болно. АУС нь бүх гэр бүлүүддээ төлөвлөгөөний явц, нөхцөл байдлын өөрчлөлтийн талаар урьдчилан мэдэгдэж байх болно.

## ТҮЛХҮҮР ХОЛБООСУУД

Хэрэв та бүхэнд өгөсөн даалгавартай холбоотой асуудал эсвэл техникийн туслалцаа авах шаардлагатай бол хүүхдийнхээ багш эсвэл сургуулийнхаа ИТС-н зохицуулагчтай холбоо барина уу. Хэрэв таны хүүхдийн сургуулийн ажилд туслалцаа хэрэгтэй үед холбоо барих эхний цэг бол танай хүүхдийн эсвэл танай сургууль юм.

[APS Engage online form \(apsva.us/engage/engage-aps-online-feedback/\)](https://apsva.us/engage/engage-aps-online-feedback/) сайтаар дамжуулан ерөнхий асуултууд асууж, эргэн холбогдох боломжтой.

**2020-21 оны зайн сургалтын хичээлийн жилд дэмжлэг болон түншлэлд баярлалаа.**